

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулах хуулийн этгээдээс  
хөдөлмөр эрхлүүлэх тодорхойлолт авахад бүрдүүлэх  
баримт бичгийн жагсаалт

№	Бүрдүүлэх баримт бичиг	Тайлбар
1.	Хүсэлт /албан бичгээр/	Тухайн онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийн талаарх товч мэдээлэл, гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах болсон үндэслэл шалтгаан, тэдгээрийн хийж гүйцэтгэх ажил, ажиллах хүчний тоо хэмжээ, улсын нэр, иргэншил, төсөл хэрэгжих байршил зэргийг дэлгэрэнгүй тодорхойлно.
2.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	Нотариатчаар баталгаажуулах шаардлагагүй.
3.	Тусгай зөвшөөрлийн хуулбар	Хүчин төгөлдөр зөвшөөрөл, хавсралтын хамт хавсаргана. Нотариатчаар баталгаажуулах шаардлагагүй.
4.	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар гадаадын хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ	Гэрээ нь бусад орны хэл дээр бол монгол орчуулгыг хавсаргана.
5.	Гадаад ажилтан, мэргэжилтний харъяалал, мэргэжлийн байдлыг тодорхойлсон баримт	Гадаад паспортын хуулбар, мэргэжлийн үнэмлэх, эзэмшсэн боловсрол, мэргэшлийн дипломны хуулбар зэргийг хавсаргана.
6.	Нийт ажилчид, түүний дотор гадаадын ажилтан, мэргэжилтний эзлэх хувь	Тухайн хуулийн этгээдийн хүсэлт гаргахаас өмнөх сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн 7 дугаар маягт/холбогдох эрх бүхий байгууллагын баталсан/-ын хуулбарыг хавсаргана.
7.	Туслан гүйцэтгэгч хуулийн этгээд	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдтэй туслан гүйцэтгэх болон бусад чиглэлээр хамтран ажиллахаар байгуулсан гэрээ, хэлцлийг хавсаргана.

8.	Газрын тосны эрлийн гэрээ болон хайгуул, ашиглалтын үе шатны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд туслан гүйцэтгэгчээр ажиллах гадаадын хуулийн этгээд	Гадаадаас авах мэргэжилтний тус компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээг хавсаргана.
9	Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэн авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд төлөх төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлсэн баримт	Баримтыг нотариатчаар баталгаажуулах шаардлагатай.